



**ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 14/20

Улаанбаатар хот

Г Гадаад харилцааны яаманд шаардлагатай
гадаад хэлний жагсаалт батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 26 дугаар зүйлийн 26.1, Дипломат албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3, “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “ур чадвар буюу гадаад хэлний тусгай шаардлага”, Гадаад харилцааны сайдын 2020 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Дипломат албан тушаал эрхлэх болзол”-ын 4.1.1-4.1.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Гадаад харилцааны яаманд нэн шаардлагатай болон шаардлагатай гадаад хэлний жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Яамны газар, нэгжийн сул орон тоог нөхөх, байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд албан тушаалын тодорхойлолтод заасан гадаад хэлний шаардлагыг өөрчлөхгүй байх, дипломат албаны мэргэшлийн тусгай шалгалтыг зохион байгуулахдаа газар, нэгжийн гадаад хэлний хэрэгцээ шаардлагыг тухай бүр харгалзан тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан гадаад хэлний мэдлэгийг чадахуйн зарчмын гол шалгуур үзүүлэлт болгон сонгон шалгаруулалт хийж байхыг Төрийн захиргааны удирдлагын газрын захирал С.Золжаргалд даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/103 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Яаманд шаардлагатай гадаад хэлийн бие даан суралцаж буй албан хаагчдыг урамшуулах журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтийг ханган, тухайн гадаад хэлийг өндөр түвшинд эзэмшсэн албан хаагч яамны хэмжээнд 5-аас доош хэмжээнд хүрвэл тухайн гадаад хэлээр албан хаагч бэлтгэх нэн шаардлагатай, 10-аас доош бол шаардлагатай ангилалд тооцон хэлний жагсаалтыг 2-3 жил тутам шинэчилж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын захирал С.Золжаргалд үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Н.АНХБАЯР

Төрийн нарийн бичгийн дарга 2021 оны
04 дугаар сарын 01-ны өдрийн 120 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



“ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМАНД ШААРДЛАГАТАЙ
ГАДААД ХЭЛНИЙ ЖАГСААЛТ”

Нэг.	Нэн шаардлагатай гадаад хэл
1	Солонгос хэл
2	Унгар хэл
3	Турк хэл
4	Казах хэл
5	Польш хэл
6	Итали хэл
7	Чех хэл
8	Вьетнам хэл
9	Болгар хэл
10	Лао хэл

Хоёр.	Шаардлагатай гадаад хэл
1	Франц хэл
2	Герман хэл
3	Испани хэл
4	Араб хэл
5	Перс хэл